

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.06.27

Мандалговь

Тус салбар зөвлөл нь Төрийн албаны шинэтгэлийн стратегүүд болон Засгийн газрын шинэчлэлийн бодлогыг орон нутагт өргөн далайцтай хэрэгжүүлж үр дүнд хүргэхийг зорилго болгон энэ ажлын хүрээнд үндсэн ажлаа төлөвлөж, тодорхой удирдамж, чиглэл, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг улирал тутам дүгнэж, эрчимжүүлж ажиллалаа.

Салбар зөвлөлөөс 2017 оны эхний хагас жилд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил, үр дүнг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу танилцуулж байна.

Нэг. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил үр дүн

Тус Салбар зөвлөлөөс төрийн албаны хууль тогтоомж, стандартуудын хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, судалгаа мэдээлэл, цахим технологид суурилсан ажил үйлчилгээг нэвтрүүлэх, төрийн албан хаагчдын чадавх, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэхэд ахиц дэвшил гаргах зорилт дэвшүүлэн тодорхой ажлууд зохион байгуулж ажилласан.

Засгийн газрын 2007 оны 186 дугаар тогтоолоор баталсан төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх улсын төлөвлөгөөнд үндэслэн, аймгийн салбар зөвлөлийн 2017 оны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тооцож ажиллаж байна.

Хоёр. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн.

Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 91 дүгээр албан тоотой ирүүлсэн загварын дагуу аймгийн салбар зөвлөлийн 2017 оны төлөвлөгөөг стратегийн 5 үндсэн зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэх 38 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур тоо чанар, хугацаагаар тодорхойлон төлөвлөж, салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулан хэрэгжүүлж, улирал тутам үр дүнг тооцож ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 94,11 хувьтай байна.

Гурав. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал

2017 оны эхний хагас жилд Салбар зөвлөлийн хурлыг 11 удаа хийсэн. Зөвлөлийн хурлаар зарим албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгох, “Оны шилдэг менежер” шалгаруулах, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын комисс байгуулах, сонгон шалгаруулалтын дүнгийн тухай, дүгнэлт гаргах тухай, албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай, зарим иргэдийн өргөдөл гомдлын тухай, төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулж явуулах, шалгалтын дүнгийн тухай, хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, төрийн байгууллагуудад төрийн албаны стандартын хэрэгжилтийг шалган зааварлах тухай зэрэг цаг үеийн тулгамдсан 42 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 46 тогтоол гаргасан.

Салбар зөвлөлийн 2017 оны 1-р улирлын хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, цахимаар сурталчилсан. Тус салбар зөвлөл 2017 оны 1 дүгээр улиралд 6 хуралдаан хийж, 24 асуудал

шийдвэрлэснээс 100%-21, 90%-3, нийт шийдвэрийн хэрэгжилт 98,75 хувьтай, 2017 оны эхний хагас жилд 11 хуралдаанаар 48 асуудал шийдвэрлэснээс 100% хэрэгжилттэй 32, 90 хувь 16, хэрэгжилтийн хувь 96,66.%-тай байна.

Салбар зөвлөлийн хуралдаанаас гаргасан 2017 оны 1-р улирал болон эхний хагас жилийн шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн, зарим байгууллагуудад шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар албан тоот өгч, хариуцсан гишүүдийг үүрэгжүүлж хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. */Салбар зөвлөлийн 2017 оны эхний хагас жилд хуралдаанаар хэлэлцсэн асуудлын төлөвлөгөө, шийдвэр, түүний хэрэгжилтийг хавсаргаав./*

Хуралдааны тэмдэглэлийг хуралдаанаас хойш 3 өдрийн дотор албажуулах талаар Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажлын төлөвлөгөөнд тусган бүрэн хөтөлж албажуулсан.

Дөрөв. Орон нутаг салбарын хэмжээнд хууль, журам заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн

Төрийн албаны стандарт, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалган туслах ажлын байнгын удирдамжийн дагуу салбар зөвлөлийн гишүүд хариуцсан сум, байгууллага, хэлтэс, агентлагууддаа төрийн албаны хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх ажлыг явуулж, хууль, тогтоомж, журам зааврын зөрчлийг арилгуулах, гарсан шийдвэрийг хангуулах арга хэмжээ тогтмол авч ирлээ.

Салбар зөвлөлүүдийн 2016 оны үйл ажиллагааны тайланд хийсэн үнэлгээний дүнг хэлэлцээд Төрийн албаны зөвлөлөөс салбар зөвлөлүүдэд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ТАЗСЗ-ийн 2017 оны 7 дугаар хуралдаанаар хэлэлцэн баталж, хагас жилийн байдлаар хэрэгжилтийг дүгнэж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилээр 92,72 хувьтай байна. */Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хавсаргаав./*

Аймгийн Засаг даргаас томилогддог сумын Засаг дарга, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын хувийн хэрэг бүрдүүлэлтэд хяналт шалгалт хийж, нийтлэг гарч байгаа зөрчил дутагдалыг арилгах талаар зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг бүх байгууллагуудад шалган зааварлаж дүн мэдээг ирүүлээд байна.

Улсын Их Хурлын 2013 оны 13 дугаар тогтоолоор баталсан Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 43-т "Төрийн албаны зөвлөл нь энэ журмыг хэрэгжүүлэх арга зүйгээр хангана" гэж заасны дагуу Төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул ажлын байранд 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж дүгнэлт гаргахдаа баримтлах зөвлөмжийг Төрийн албаны зөвлөлөөс ирүүлснийг бүх төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлж ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2-т Төрийн албан хаагчийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж, төрийн албыг хууль бус томилгоогүй болгоно гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын удирдах ажилтан, төрийн захиргааны албан хаагчдын томилгоог холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулан томилж, томилгооны зөрчилгүй ажиллах талаар төрийн байгууллагуудад 1 дүгээр улиралд хийсэн ажлын тайлан авч нэгтгэн Төрийн албаны салбар зөвлөлд мэдээлж, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

2017 оны 1 дүгээр улиралд нийт 81 сул ажлын орон тоо гарснаас суманд 39, агентлагт 42 байна. Үүнээс 64 ажлын байрны захиалга ирүүлсэн. Үлдсэн 17 ажлын байрны 5 нь буюу ХХҮХ-ийн 4 даргын ажлын байр, УБХ-ийн Цагаандэлгэр

сум хариуцсан мэргэжилтний ажлын байрууд нь дээрээс томилогддог ажлын байрууд байна.

Нэгдсэн эмнэлгийн дарга, ХХҮХ-ийн Дэлгэрхангай сум хариуцсан мэргэжилтний ажлын байрны захиалга ирүүлээгүй байна. Мөн Өлзийт, Цагаандэлгэр, Сайхан-Овоо, Сайнцагаан сумын ГИЦС, Луус сумын цэцэрлэг, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Адаацаг сумын ЭМТ, Сайхан-Овоо сумын Төрийн сангийн мэргэжилтний ажлын сул орон тоо гарсан хэдий ч захиалгаа өгөөгүй байна.

Салбар зөвлөлөөс 47 ажлын байранд нэр дэвшүүлж, 11 ажлын байранд мэргэшлийн шалгалт зохион байгуулаад байна.

Тав. Орон нутаг салбарын хэмжээнд хууль, журам заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Хууль, журам, заавар төрийн албаны стандартын хэрэгжилтэнд 2017 оны 1 сард хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг ХШҮТ-тай хамтран тусгай удирдамжийн дагуу зохион байгуулсан.


Хяналт шалгалтын явцад сумд байгууллагуудын стратеги төлөвлөгөөгөө шинэчилсэн, Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөртэй түүнийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөө гарган ажилласнаар төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан, сум байгууллагуудад албан хаагчдыг амьдрах орон сууцаар хангасан, аймгийн туршлагын санд багш нарын хичээл, болон багш нарын сурган хүмүүжүүлэх илтгэлийг оруулж бүртгүүлсэн, Төрийн албан хаагчийг төрийн албан хаагчдаас санал авч шалгаруулсан, албан хаагчдаа дотооддоо болон гадаад улсад туршлага судлуулсан, иргэдээс төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, ёс зүйн талаар санал асуулга авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн, байгууллага бүр төрийн албан хаагчдын судалгааг жил бүр шинэчилж хэвшсэн, Төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон ёс зүйн харилцааны ур чадварыг хөгжүүлэх замаар иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлийн ярилцлага хэлэлцүүлэг зохион байгуулсан, Төрийн захиргааны албан хаагчдын ажлыг улирал бүр тусгай шалгуур үзүүлэлтээр дүгнэж, үнэлгээний дүнг жилийн эцсийн ажлын үзүүлэлтэд оруулан дүгнэдэг зэрэг ажлын сайн туршлагауд байлаа.

Мөн үүний зэрэгцээ ажлын зөрчил дутагдал байгааг арилган сайжруулах чиглэлийг холбогдох байгууллагуудад зөвлөмжөөр өгч, сум байгууллагуудад гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж хэвшсэн.

Зургаа. Төрийн байгууллагын албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн. Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Төрийн бүх шатны байгууллагад төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, төрийн албаны шинэчилсэн хууль тогтоомж, стандартуудыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэн чадваржуулж төрийн албаны залгамж чанарыг дархлаажуулах, төрийн үйлчилгээний нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллахад гол анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах сургалтын графикийг улирал тутам гарган хэрэгжүүлж 2012-2017 онд давхардсан тоогоор 587 удаагийн сургалтанд 21488 төрийн албан хаагчид хамрагдсан байна. Үүнийг он оноор харуулбал:



Төрийн албан хаагчдын 2017 оны нэгдсэн сургалтын график болон улирал бүр орон нутагт зохион байгуулах сургалтын графикийг гарган хэрэгжүүлж байна. 2017 онд Улаанбаатар хотод холбогдох яам агентлагуудад 85, Удирдлагын академид зайны сургалтанд 20 шинээр томилогдсон албан хаагид, Богино

хугацааны сургалтанд 105 төрийн захиргааны болон нийгмийн салбарын удирдах ажилтан хамрагдсан.

Орон нутагт эхний хагас жилд 44 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1648 төрийн албан хаагчид хамрагдсан байна.

Төрийн байгууллагын удирдлагуудад төрийн албаны стандарт, ёс зүй, нутгийн удирдлага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, удирдлагын манлайлал, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, цаашид хэрэгжүүлэх бодлого хамтын ажиллагааны талаар мэдээлэл, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Сахилга, хариуцлага, ёс зүй төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт сургалт, семинарыг зохион байгууллаа. Уг сургалтанд сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн төвийн бүх төрийн болон төрийн өмчит байгууллагуудын удирдлагууд 150 гаруй хүн хамрагдлаа.

Мөн төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Багийн Засаг дарга нарын 2 өдрийн сургалтад 66 хүнийг хамруулан зохион байгуулсан нь шинээр томилогдсон багийн дарга нарт ажлын арга барилаа олоход үр дүнгээ өгсөн ажил боллоо.

Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран Захиргааны ерөнхий хууль,



захиргааны хэм хэмжээний акт сэдвээр 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарт сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд нийт 100 төрийн албан хаагч хамрагдсан.

“Төрийн үйлчилгээний чанар хүртээмж” сургалтыг

Монгол улсын ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран 150 гаруй төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан нь төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн үр дүнтэй ажил боллоо.

2017 оны 07 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх эрүүгийн хууль, зөрчлийн тухай, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, зөрчил шалган шийдвэрлэх тухай,

шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, прокурорын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан уг хуулиудын үзэл баримтлал, шинэ зохицуулалтын талаар холбогдох хуулийн байгууллагуудын албан тушаалтнуудад мэдлэг олгох, хуулийн үзэл баримтлалыг таниулах сургалт боллоо. Уг сургатыг хууль зүйн ямнаас зохион байгуулсан бөгөөд ХСИХ-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх албаны тэнхимийн багш, дэд хурандаа Б.Хишигтогтохоор ахлуулсан 9 багш 5 хоногийн турш сургалтыг явууллаа. Сургалтанд аймгийн хуулийн байгууллагуудын алба хаагчид хамрагдлаа.

Төрийн албан хаагчдын гадаад сургалт арга хэмжээнд хамрагдах хүрээг нэмэгдүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж, 2017 онд Япон, БНХАУ, БНСУ-д нийт 4 гадаад сургалт болон бусад арга хэмжээнд 22 хүн хамрагдснаас 15 төрийн албан хаагч байна.

Байгууллагууд жил бүр албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээний судалгааг авч нэгтгэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд Ерөнхий менежерүүдийн хувьд үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, ажлын арга барил, менежментээр бусдыгаа хошуучлан ажиллаж байгаа Төсвийн шууд захирагч нарын Шилдэг менежерт тодорхойлсон 2 хүний тодорхойлолтыг Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, Байгаль орчин, айлал жуулчлалын газрын дарга Н.Гантулга, Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга С.Мядагмаа нарыг аймгийн “Шилдэг менежер”-ээр өргөмжилж, шагнаж урамшууллаа.

Байгууллагууд жил бүр албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээний судалгааг авч нэгтгэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга, агентлагын дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд төсвийн байгууллага бүр суралцагч байгууллага болох чиглэлд туршлага хуримтлуулан ажиллах зорилт дэвшүүлэн үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэн эрчимжүүлж ажиллалаа.

ДУНДГОВЬ АЙМАГТ ГОВИЙН БҮСИЙН АЙМАГ, СУМДЫН ЗДТГ-ЫН

ДАРГА НАРТАЙ ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТ ЯВУУЛСАН ТУХАЙ ТАЙЛАН

Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 28.1.1, 31.2, Цэргийн албаны тухай хуулийн 33.10, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 3.1.3-ийг тус тус үндэслэн Говийн бүсийн аймаг, сумдын ЗДТГ-ын цэргийн бэлтгэл сургалтыг Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, дайчилгааны даалгаварыг биелүүлэх, орон нутгийн цэргийг зохион байгуулахад байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, аймаг сумдын ЗДТГ-ын дарга нарт мэдлэг дадлага олгох, цэргийн бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор тус аймагт 2017 оны 08 дугаар сарын 02-05-ийг дуустал Адаацаг сумын нутаг дэвсгэр дэхь “Бүрдийн Уянга хүүхдийн зуслан”-д зохион явууллаа.

Тус сургалтанд БХЯ-ны СБТГ-ын ОНХ, улсын дайчиллагааны хэлтсийн дарга, хурандаа С.Ганбямба, ЗХЖШ-ын БСТГ-ын цэргийн дайчилгааны хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа С.Батболд нарын 4 хүн, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын

дарга Ц.Дашцэрэн, Цэргийн штабын бүрэлдэхүүн, сумдын ЗДТГ-ын дарга нарын 25 хүн, Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын дарга Д.Содном, Цэргийн штабын дарга, сумдын ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга нарын 12 хүн, Дорноговь аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, Цэргийн штабын бүрэлдэхүүн, сумдын ЗДТГ-ын дарга нарын 23 хүн, Дундговь аймгийн ЗДТГ-ын дарга Эрдэнэсүрэн, Цэргийн штабын бүрэлдэхүүн, сумдын ЗДТГ-ын дарга нарын 19 хүн, Өмнөговь аймгийн Цэргийн штабын бүрэлдэхүүн, сумдын ЗДТГ-ын дарга нарын 17 хүн, нийт 100 төрийн захиргааны албан хаагч, цэргийн албан хаагч нар 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдөр ирж байрлан оролцлоо.

Цэргийн бэлтгэл сургалтын хөтөлбөр, нийт бие бүрэлдэхүүний дагаж мөрдөх цагийн хуваарийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Х.Батбилэгээр батлуулан БХЯ-ны СБТГ-ын дарга, бригадын генерал Г.Сайханбаяр, аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ нараар хянуулсан.

Батлагдсан хөтөлбөрийн дагуу эхний буюу 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдөр “Бүрдийн Уянга хүүхдийн зуслан”-гийн хурлын зааланд “Орон нутагт Батлан хамгаалах тухай багц хуулийг хэрэгжүүлэхэд аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарын үүрэг оролцоо” сэдвээр лекц, харилцан ярилцах, асуудал дэвшүүлэх, нэгдсэн дүгнэлтэнд хүрэх аргаар явуулсан.

Сургалтыг нээж аймаг, орон нутгийн өнөө ба ирээдүйн нийгэм, эдийн засгийн байдлыг аймгийн ЗДТГ-ын дарга, Ц.Эрдэнэсүрэн танилцуулж, Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, Батлан хамгаалах эрх зүйн шинэчлэл, орон нутагт хэрэгжүүлэх арга зам сэдвээр БХЯ-ны СБТГ-ын ОНХ, улсын дайчиллагааны хэлтсийн дарга, хурандаа С.Ганбямба, Зэвсэгт хүчний шинэчлэл, өнөөгийн байдал, Цэрэг татлагын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал сэдвээр ЗХЖШ-ын БСТГ-ын Цэргийн дайчилгааны хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа С.Батболд, Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт, түүнийг орон нутагт зохион байгуулж байгаа байдал сэдвээр Өмнөговь аймгийн Цэргийн штабын дарга, хурандаа Ж.Амаржаргал, Дайчилгааны бэлэн байдлын зэрэгт шилжих үед дайчилгааны даалгавар биелүүлэх нь сэдвээр Дорноговь аймгийн Цэргийн штабын дарга, хурандаа Л.Баатар, Цэргийн бүртгэлийг орон нутагт хэрхэн зохион байгуулж явуулах, хамрагдалтыг нэмэгдүүлэх боломжууд сэдвээр Баянхонгор аймгийн Цэргийн штабын дарга, хурандаа Б.Энхбаатар, Цэрэг татлагад ЗДТГ-ын дарга нарын оролцоо сэдвээр Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ЗДТГ-ын дарга, Б.Хатантөмөр, Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх,

хураан авах, орлогыг ашиглах талаар Дундговь аймгийн ЦШ-ын тоо бүртгэлийн офицер, хошууч Г.Цэрэндолгор нар тус тус онол, арга зүйн лекц орсон.

Лекцын төгсгөлд аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нартай нээлттэй хэлэлцүүлгийг дээрх сэдвүүдийн дагуу ололт, дутагдал тулгамдаж буй асуудлын талаар аймаг бүр 10 минут хэлэлцүүлэг явуулсан.

“Орон нутагт дайчилгааны даалгаварыг биелүүлэх, орон нутгийн цэргийг зохион байгуулах” сэдэвт дараах өдрийн сургалтыг 08 дугаар сарын 04-ны өдрийн 05.00 цагт Адаацаг сумын ЗДТГ-ын бүрэлдэхүүнд “Дайчилгааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллуулах цагийн байдал” өгснөөр тус сумын төвд Батлан хамгаалах товчоо, дайчилгааны даалгавартай хүн, техникийг зарлан дуудаж дайчилгааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үзүүлэх сургуулийг эхлүүлсэн.

Сургалтад хамрагдаж буй бүрэлдэхүүн байрлаж буй районоос цуваагаар хөдөлгөөн үйлдэн Адаацаг сумын төвд очсон.

Тус сумын ЗДТГ-ын хурлын танхимд Засаг даргын захирамж, цагийн байдал, хэрэгжүүлж байгаа ажлын талаар Адаацаг сумын ЗДТГ-ын дарга, бэлтгэл дэслэгч Б.Уранцэцэг танилцуулан, Цугларах байрны үйл ажиллагаа, хөтлөгдөх бичиг баримттай танилцуулах, Дайчилгаагаар ирэх бүрэлдэхүүн, авто техникийг цугларах, шилжүүлэх байранд хүлээн авах бэлтгэл үйл ажиллагаатай танилцуулах, Орон нутгийн цэргийг зохион байгуулах, бүртгэлтэй мотоцикль, агт морь, ангийн бууг цуглуулах, бүртгэл явуулах, Орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулж байгаа ажиллагааг Адаацаг сумын батлан хамгаалах товчооны удирдах бүрэлдэхүүн тайлбарлан танилцуулсан.

Төгсгөлд сургалтын удирдлага, хамрагдсан бүрэлдэхүүн үзүүлэх сургуулийн талаар санал, дүгнэлт гарган ололтой тал, дутагдалтай талыг харилцан ярилцан нэгдсэн ойлголттой болсон.

Өдрийн хоолыг Адаацаг суманд идсэнээр сургалтын бүрэлдэхүүн өөрсдийн байрлаж буй байрлалын район руу хөдөлгөөн үйлдсэн.

Чөлөөт цагаар зохиох спортын арга хэмжээг нийт бие бүрэлдэхүүний нөхөрсөг байдалыг дээшлүүлэх, нэгдмэл, нэг хамт болгох зорилгоор “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг бооцоот хэлбэрээр зохион байгуулан явуулж Дорноговь аймгийн бүрэлдэхүүн тэргүүлж, удаах байранд Өмнөговь аймгийн бүрэлдэхүүн шалгаран ту тус байр эзлэсэн.

Соёл хүмүүжлийн цагаар оройн хоолны дараа аймгийн Хүүхдийн театрын бүжиг, ардын цөөхүүл хөгжмийн тоглолт, циркийн дугуйлангийн хүүхдүүдийн тоглолт хийн үзүүлсэн.

Сургалтын хаалтын ажиллагаа, дүнг БХЯ-ны СБТГ-ын ОНХ, улсын дайчиллагааны хэлтсийн дарга, хурандаа С.Ганбямба, ЗХЖШ-ын БСТГ-ын цэргийн дайчилгаан хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа С.Батболд нар гарган сургалтанд амжилттай оролцсон зарим хүмүүст Батлан хамгаалахын сайдын тушаалаар БХЯ-ын “Хүндэт жуух бичиг”-ээр, “Эх орны төлөө-3” медаль, ЗХЖШ-ын даргын тушаалаар бэлтгэл ахмад, ахлах дэслэгч, дэслэгч цолоор сумдын ЗДТГ-ын дарга нарыг шагнасан.

Сургалтанд хамрагдсан бүрэлдэхүүн хээрийн эрээн хувцастай оролцож батлагдсан “Дагаж мөрдөх цагийн хуваарь”-ийн дагуу өглөөний гүйлт гимнастик, оройн тоо, зугааллагийг хийлгэж нэгдсэн арга хэмжээнд бүлгүүдийн дарга нар Зэвсэгт хүчний “Жагсаалын дүрэм”-ийн дагуу удирдан зохион байгуулж бүрэн хамруулсан.

Нийт сургалтын хугацаанд хичээлийн хэрэгсэл, үзүүлэн таниулах материалаар бүрэн хангасан, тодорхой шалтгаанаар хичээл сургууль тасарсан цаг байхгүй, заагдсан сургалтын программыг бүрэн хангасан.

Хоолыг орц, нормоор нь “Хоолны цэс”-ийн дагуу өдөрт 3 удаагийн 4 халуун хоолоор ханган үйлчиллээ.

Сургалтыг осол авааргүй, зохион байгуулснаас гадна аймгийн Цагдаагийн газрын Хэв журмын тасгийн офицер-2 ахлагч-3 хүний бүрэлдэхүүнтэй хэсэг ирж нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг ханган ажилласан.

ТАЙЛАНГ ГАРГАСАН:

ЦШ-ЫН ДАРГА, ХУРАНДАА

Б.АМАРЖАРГАЛ

Долоо. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил үр дүн

Төрийн байгууллагуудад Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй ажиллах талаар 2017 оны үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг сургалт семинараар сумдын ЗДТГ-ын дарга нарт өгч, эрчимжүүлж ажилласан .

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь заалтын дагуу нийт сум, хэлтэс, агентлагууд байгууллагынхаа төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөтэй тухайн жилдээ 3-6 зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж ажилласан нь зохих үр дүнгээ өгч байна.

Сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжид байгууллагуудын албан хаагчдын сургалт ба ажиллах нөхцөл,

нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг шалгуур үзүүлэлтээр оруулан шалган дүгнэж заавар зөвлөмж өгч ажилласан.

Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох шуурхай байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын техник хангамжийг нэмэгдүүлж, цахим программ нэвтрүүлэн үр дүнд хүрч байна.

Төрийн байгууллагуудыг стандартын цахим хуудастай болгож, И-оффис системийг хөгжүүлж, сум байгууллага бүрийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлтийг цахим орчинд шилжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн хэвшүүлж байна.

Бүх сумдад интернетийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цахим орчин бүрдүүлсэн. Байгууллага хоорондоо мэдээлэл солилцох, байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрээр сурталчилах боломж бүрдсэн. Энэ онд И-оффис программын хэрэглэгчийн тоог 300 гаруй хүнээр нэмэгдүүлсэн байна.

2017 онд аймгийн хэмжээнд ажилдаа амжилт гаргаж хамт олноо манлайлан ажилласан 2 байгууллагыг аймгийн “Тэргүүний хамт олон”-оор шалгаруулж, аймаг орны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан 2 иргэнийг “Аймгийн хүндэт иргэн”-ээр, 2 иргэнийг “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж алдаршуулан, 9 ажилтныг аймгийн “Тэргүүний ажилтан”, 25 малчныг аймгийн “Аварга малчин” цол тэмдгээр, 120 хүнийг “Хүндэт тэмдэг”-ээр, 161 иргэнийг “Жуух бичиг”-ээр тус тус шагнаж урамшуулсан.

Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдын төрийн байгууллагуудыг халаалтын нэгдсэн системд холбон ажиллах нөхцөлийг сайжруулсан.


Говь-Угтаал суманд ердийн галлагаатай орон сууцанд 10 албан хаагч амьдарч байсны 3 нь нэгдсэн халаалтдад холбогдож, орон сууцны нөхцөлийг нь сайжруулсан.

Говь-Угтаал сум 120 гаруй ТАХ-тай тэдний өмнө тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилгоор ТАХ-ын зөвлөгөөныг Зохион байгуулан 11 чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулахад залуу боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад ялангуяа орон байрны тохь тухтай байдлыг хангах шаардлагатай байсан. Нийт 101 албан хаагчдын 84,2 хувь нь цалингийн зээлтэй байгаа нь төрийн албан хаагчид орон сууцныхаа асуудлыг өөрсдөө шийдвэрлэхэд хүндрэлтэй байсан. Иймээс төрийн албан хаагчдын 8 айлын сууцыг барих ажлыг эхлүүлж, ОНХС-гийн хөрөнгөөр Сум дундын эмнэлгийн эмч мэргэжилтний 4 айлын сууцыг засварлах ажлыг хийж байна.

Найм. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Төсвийн байгууллагуудад томилгооны зөрчилгүй ажиллуулах зорилгоор захиалгыг үндэслэн 2012-2017 онд төрийн жинхэнэ албаны болон үйлчилгээний байгууллагын удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 31 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 127 ажлын байрыг нийтэд зарлаж, 174 хүн сонгон шалгаруулалтад бүртгүүлж, үүнээс 96 нь шалгалтандаа тэнцэж 65-ыг нь тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлсэн байна. Үүнийг оноор харуулбал:

УДИРДАХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ



Төсвийн байгууллагуудын санал, захиалгыг үндэслэн 2017 онд төрийн захиргааны 10, үйлчилгээний 16 байгууллагын дарга /эрхлэгч/-ын албан тушаалд томилогдох ажилтнуудын сонгон шалгаруулалтыг 5 удаа зохион байгуулсан.

Энэхүү 5 удаагийн сонгон шалгаруулалтаар 24 ажлын байранд 46 иргэн бүртгүүлж орсноос 27 иргэн тэнцэж, 17 иргэнийг нэр дэвшүүлсэн.

4 иргэнийг нь Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гарган сум, байгууллагын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшүүлж, томилуулсан.

Сонгон шалгаруулалтыг УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол, ТАЗ-ийн 2013 оны 14 болон 60 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу зохион байгуулсан. Сонгон шалгаруулалт бүрийг явагдах өдрөөс 21 хоногийн өмнө Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, аймгийн www.Dundgovi.gov.mn сайт, facebook болон орон нутгийн Дундговь, телевиз, аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбар, аймаг, сумдын Засаг дарга нарын шуурхай цуглаанд 2-3 удаа мэдээлэн сурталчилж, дүн мэдээг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, Засаг даргын шуурхай цуглаан, мэдээллийн самбараар тогтмол сурталчилж хэвшсэн.

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын сорилын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.


Удирдах ажилтны сонгон шалгаруулалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн жагсаалтыг гаргаж, ил тод сурталчилж байна.

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг явуулах аймгийн журам боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 18 дугаар тогтоолоор баталгаажуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Ес.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод байдлыг хангасан байдал, үр дүн

Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийг сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтыг 2012 оноос хойш цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 362 ажлын байр нийтэд зарлагдаж, 965 иргэн бүртгүүлж, эдгээрээс 3366 иргэн шалгалтад тэнцэж, өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авсан 110 иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тухайн ажлын байрандаа нэр дэвшүүлэн томилогдсон байна. Үүнийг оноор харуулбал:

ТӨРИЙН АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТ



Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг үндэслэн Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2017 оны эхний хагас жилд 2 удаа зохиж журам, удирдамжийн дагуу ил тод, нээлттэй зохион байгуулж явуулсан.

Энэхүү 2 удаагийн мэргэшлийн шалгалтаар 29 ажлын байр зарлагдсанаас 28 ажлын байранд 165 хүн бүртгүүлж, эдгээрээс 42 хүн шалгалтандаа тэнцэж, өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авсан 21 иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тухайн ажлын байрандаа нэр дэвших болзол хангасан байна.

/Төрийн албаны мэргэшлийн шалгалтын мэдээллийг www.dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл талбарын Ил тод байдал хэсгийн Төрийн жинхэнэ албаны нөөц хэсэгт болон бусад мэдээллийн талбараар сурталчилж байршуулсан болно/

Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг ТАЗ-ийн 2013 оны 86 дугаар



тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу зохион байгуулсан. шалгалт бүрийг явагдах өдрөөс 21 хоногийн өмнө Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, аймгийн www.Dundgovi.gov.mn сайт, орон нутгийн Ард телевиз, аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбар, аймаг, сумдын Засаг дарга нарын шуурхай цуглаанд

3-4 удаа мэдээлэн сурталчилж, дүн мэдээг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, Засаг даргын шуурхай цуглаан, мэдээллийн самбараар тогтмол сурталчилж хэвшсэн.

Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд 23-26 хүний багтаамж бүхий цахим шалгалт явуулах байр бэлтгэн, шалгалтын явцын бичлэг хийж, танхимын гадна талд телевизээр шалгалтын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй харуулах боломж нөхцөлийг бүрдүүлж, шалгалтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд хамрагдсан бусдаасаа хамгийн өндөр оноо авч 1-ээр гарсан 13 иргэнийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлснээр 11 иргэн томилогдож, 2 иргэн томилогдохоос татгалзсан байна.

Арав. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн

Төрийн жинхэнэ албаны нөөцийн санг анх орох иргэний нөөц, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц гэсэн 2 ангиллаар бүрдүүлсэн.

2017 оны эхний хагас жилийн байдлаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн санд дэс түшмэлийн 52, туслах түшмэлийн 12 нийт 64 иргэн бүртгэлтэй байгаа. /Төрийн жинхэнэ албан нөөцийн мэдээллийг www.dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл талбарын Ил тод байдал хэсгийн Төрийн жинхэнэ албаны нөөц хэсэгт байршуулсан болно./

Нөөцийн сангийн баяжилтийг тогтмол хийж, нөөцийн бүртгэлд байгаа иргэдийг мэргэшлийн чиглэлээр нь ангилан, нэрсээр нь тодруулж гарган, 13 байгууллагад нөөцийн мэдээллээр үйлчилсэн байна. Нөөцийн сангийн мэдээллээ байгууллагууд цахим хуудаснаас авч байна.

Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо, түүнийг нөхөх талаар авсан арга хэмжээний мэдээллийг орон нутгийн телевиз, Засаг даргын шуурхай цуглаан, семинар цугларалтын үеэр болон Салбар зөвлөлийн мэдээллийн самбараар нийтэд ил тод болгож, тогтмол мэдээлж хэвшсэн.

Салбар зөвлөлөөс сум, хэлтэс, агентлагуудын захиалгын дагуу нөөцийн жагсаалтад бүртгэлтэй байсан 13 иргэнийг захиалгат ажлын байранд нэр дэвшүүлж, 15 иргэн томилуулсан.

Удирдах ажилтны нөөцөд 9 хүнийг бүртгэсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас нэгжийн даргад нэр дэвшүүлсэн 4 хүний асуудлыг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн, дүгнэлт гаргаж томилуулсан.

Арван нэг. Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн санг бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөц бүрдүүлэх журам” –ын сум байгууллагад холбогдох заалтуудыг хяналтанд авч хэрэгжилтийг улирал тутам дүгнэн ажиллаж байна.

2017 онд төрийн албан хаагчийн нөөцийн жагсаалтанд 9 хүнийг шинээр бүртгэж, 13 хүнийг нөөцөөс нэр дэвшүүлж, 6 сарын байдлаар төрийн жинхэнэ албаны нөөцөд 23 хүн бүртгэлтэй байна.

Нөөцийн мэдээллийг Dundgovi.gov.mn цахим хуудсны Төрийн албаны салбар зөвлөл талбарын “Ил тод байдал” хэсэгт байршуулан сурталчилж байна.

Арван хоёр. Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээг байгуулах, дүгнэх асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах дүгнэх журмын дагуу Сумдын Засаг дарга, төрийн захиргааны байгууллагууд, төсөвт байгууллагын дарга нартай байгуулах 2017 оны үр дүнгийн гэрээг байгуулсан.

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын болон төрийн захиргааны албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинд өгсөн үнэлгээг салбар зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн, зохих дүгнэлт өгч баталгаажуулан, цаашид анхаарах асуудлаар нийт сум хэлтэс, агентлагуудын удирдлагуудад зөвлөмж, чиглэл өгөх ажил хэвшил болсон.

Төрийн байгууллагууд зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-уудыг нийт сум, байгууллагуудад мөрдүүлэн ажиллаж, ерөнхий менежерүүдээс дээрх журам, заавруудыг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт шинжилгээ хийж, анхаарах асуудлуудаар тухай бүр нь заавар, зөвлөмж өгч арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

Ерөнхий менежер, удирдах ажилтнуудын манлайллыг аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээг дүгнэх нэг харгалзах үзүүлэлт болгон авч үзэж байна.

Аймгийн Засаг даргаас хэлтэс агентлагийн дарга нар, сумдын Засаг дарга нартай 2016 онд үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн явцыг сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд явуулсан хагас, бүтэн жилийн ХШҮ-ний үеэр нийт сумдад шалган дүгнэж, цаашид ажил эрчимжүүлэх үүрэг даалгавар өгсөн.

Мөн төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээний мөрөөр журамд заасны дагуу шатлал ахиулах, шинээр зэрэг дэв олгох буюу өмнөх зэрэг дэвийг нь ахиулах, мөнгөн урамшуулал олгох зэрэг холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.

2016 оны үр дүнгийн гэрээний үнэлгээгээр А болон В үнэлгээ авч, зэрэг дэв олгох шаардлагыг хангасан 55 төрийн жинхэнэ албан хаагчдад аймгийн Засаг даргын 2017.02.13-ны А/44 дугаар, захирамжаар албан тушаалын зэрэг дэв шинээр олгуулах, өмнөх зэрэг дэвийг ахиулах арга хэмжээ авсан.

ЗДТГ-ын албан хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж, 4 хүнд ажилласан жилийн нэмэгдэл, 4 хүнд мэргэжлийн зэргийн нэмэгдэл, 4 хүнд цалингийн шатлал ахиулж, холбогдох шийдвэрийг гаргасан.

Арван гурав. Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Төрийн албан хаагчдын дунд ёс зүйн, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах талаар сум байгууллагын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж байгууллагууд тусгай төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Аймагт нийт 23 төрийн захиргааны байгууллагад 3-7 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн хороо байгуулан ажиллуулж байна.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага дээшлүүлэх зорилгоор “Сахилга хариуцлагыг сайжруулах тухай” аймгийн Засаг даргын 2017 оны 02 тоот захирамж гаргаж бүх шатны ажлын сахилга хариуцлагыг сайжруулах ажлыг зохион байгуулж үр дүнд хүрч ажиллаж байна.

Сум, байгууллагуудад Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах, төрийн албан хаагчидтай ёс зүйн гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг мөрдөж ажиллах, төрийн албан хаагчдын ёс зүйн талаар иргэдээс сэтгэл ханамжийн үнэлгээ авч дүгнэлт хийж, үр дүнг төлөвлөгөөндөө тусгах, цаг баримтлах, цаг бүртгэх арга хэмжээ үр дүнтэй зохион байгуулах талаар ЗДТГ-ын даргын албан даалгавар гаргаж хэрэгжүүлэх, Ёс зүйг дээдлэгч хамт олон болох” сарын аян өрнүүлэх, байгууллага ёс зүйн зөрчил

гаргасан ажилтанд ганцаарчилсан зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

Арван дөрөв. Өргөдөл гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас бүтэн жилээр ирүүлсэн байдал:

Иргэдээс болон төрийн албан хаагчдаас салбар зөвлөлд 20 өргөдөл, гомдол ирснийг 9-ийг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, бусдыг нь шууд хариу өгөх замаар шийдвэрлэсэн.

Ирсэн өргөдлийг бүтцээр нь авч үзвэл нөөцөөс нэр дэвшүүлэх буюу ажилд орохыг хүссэн 7 байгаа нь хамгийн их буюу нийт ирсэн өргөдлийн 35 хувийг эзэлж байна. Ажилд буцаан оруулах тухай 4, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгүүлэх тухай 4 өргөдөл, бусад 5 ирсэн байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ыг баримталж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнөх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болгоход анхаарч, салбар зөвлөлд ажлаас чөлөөлснийг эс зөвшөөрч ирүүлсэн 3 өргөдлийг журмын дагуу маргаан хянан шийдвэрлэх комисс томилон шийвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа байна.

Ёс зүйн зөрчлийн мэдээг хагас жил тутам авч нэгтгэн дүгнэж хэвшсэн. 2017 оны эхний хагас жилийн ёс зүйн хороодад ирсэн өргөдөл байхгүй байна.

Арван тав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн:


Салбар зөвлөлөөс хийсэн ажлын тайланг 7 хоног тутам Засаг даргын шуурхай цуглаан болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчилан ажиллаж байна.

Дундговь аймгийн Dundgovi.gov.mn цахим хуудсанд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах “Төрийн албаны салбар зөвлөл” талбар нээн үйл ажиллагааг нь тогтмолжуулаад байна. Уг талбарт танилцуулга, шалгалтын зар, ил тод байдал, тогтоол шийдвэр, эрх зүйн акт, холбоо барих зэрэг булан нээн үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж хэвшсэн.

2017 онд удирдах ажилтны сонгон шалгаруулалт, мэргэшлийн шалгалт, төрийн албан хаагчийн нөөцийн зар, хуралдааны тойм, шийдвэрийн хэрэгжилт, шалгалтын дүн, салбар зөвлөлийн тогтоол, төлөвлөгөө, тайлан, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн мэдээлэл зэрэг нийт 15 мэдээллийг шинээр тавьж нийтэд үйл ажиллагаагаа сурталчилсан. Мөн түүнчлэн аймгийн Дундговь телевизид 8 удаа, Засаг даргын шуурхай цугтаанд 7 хоног бүр буюу нийт 30 гаруй удаа үйл ажиллагааныхаа талаар мэдээлсэн байна.

Бүх сумдын төв, малчдад мэдээлэл хүргэдэг Аюулаас урьдчилан сэргийлэх цогцолборын FM радиогоор сар бүрийн 1-ны өдөр сарын хийсэн ажлын мэдээлэлээ дамжуулсан.

Төрийн албаны мэргэшлийн шалгалт, төрийн жинхэнэ албаны болон төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар мэдээллийг ТАЗ-ийн болон аймгийн вэб сайт, Засаг даргын шуурхай мэдээлэл, орон нутгийн Ард телевиз, аймаг, сумын ЗДТГ-ын мэдээллийн самбараар мэдээлж сурталчилж хэвшсэн.



Бүх шатны төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, нийгмийн хүндрэл бэрхшээл, асуудлын талаарх иргэдийн санал гомдлыг хүлээн авч холбогдох төрийн байгууллагад хүргэн шийдвэрлүүлэх, хариуг иргэдэд түргэн шуурхай хүргэх цахим үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санал өргөдөл гомдлын цахим сайтад 236 санал хүсэлт, өргөдөл гомдол бүртгэгдсэн бөгөөд

шийдвэрлэлт 84.3%-тай байна. Иргэдээс ирсэн санал хүсэлтийг тухай бүр цахим программд оруулж, холбогдох газруудад хуваарилан шийдвэрлүүллээ. Мөн Засгийн газрын цахим сайт 11-11 төвд ирсэн 5 асуудлыг судлан хариуг өгч шийдвэрлэлтийн хувь-100% байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу Төрийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг дээшлүүлэх сумдын иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулж иргэдийн санал бодлыг сонсох, төрийн албан хаагчдад зөвлөн туслах зорилгоор Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнээр ахлуулсан ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, төрийн байгууллагуудын удирдлага, төрийн албан хаагчид 70 гаруй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Гурвансайхан, Өндөршил сумдын иргэдэд төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэх “Иргэдээ сонсье” нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Төрийн захиргаа удирдлагын хүрээнд Гурвансайхан, Өндөршил сумын төрийн байгууллагуудад Мэдээллийн технологийг нэвтрүүлэх арга зүйн зөвлөгөө сургалтыг 44 албан хаагчид, Нийгмийн бодлогын ажилтнуудад СӨГ шийдвэрлэлтийн тайлан, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон бүртгэл хяналтанд авах тухай байгууллагын улирал болон жилийн тайланг хэрхэн гаргах талаар заавар зөвлөгөө, Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, гамшгаас хамгаалах, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн норматив, дүрэм, журмын хэрэгжилтийг шалган заавар зөвлөгөө өгч ажиллалаа.



Нийгмийн бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 9 хүнд үйлчилгээ үзүүлж, 30 хүнд гарын авлага тараасан байна. Аймгийн Төв номын сангаас Зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлж 317 номоор үзэсгэлэн гаргаж, 4 төрлийн гарын авлага тарааж нийт 213 иргэнд үйлчилж иргэдийн хүсэлтийн дагуу нийтийн номын санд ном солилцоогоор 35 ш номыг үлдээлээ.

Биеийн тамир, спортын газраас 10 ном, ажлын байрны дасгалын зураг 14, CD 4 ширхэгийг тарааж, төрийн албан хаагчдыг хийж хэвшихийг зөвлөн, хүн амын бие бялдарын сорилын программыг сумын биеийн тамирын арга зүйчийн компьютерт суулган өгч арга зүйгээр хангалаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 160 иргэдэд “Хүүхдийн төлөө хөрөнгө оруулалт”, “Хүүхэд хамгааллын хууль” Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль” зэрэг 3 төрлийн нийт 320 ширхэг гарын авлагыг тарааж, Хүүхэд гэр бүл хөгжил хамгаалал, залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн тухай цаашид авч хэрэгжүүлэх ажлын зорилго зорилтын талаар мэдээллийг 52 иргэнд хүргэж ажиллалаа.

Эрүүл мэндийн газраас Дотрын эмч 180 үйлчлүүлэгчийг үзлэгт хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Шинээр цусны өвчин 3, бамбай булчирхайн дутагдал 1, элэгний хатуурал 2, зүрхний архаг дутагдал 2, нийт 8 өвчлөлийг илрүүлж, дараагийн шатлалын эмнэлэгт илгээлээ.

Дүрс оношлогооны эмчийн үзлэгт нийт 225 үйлчлүүлэгчийг хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Цөсний чулуу 23, шохойжсон бэтэг 2, элэг өөхөлсөн 4, түрүү булчирхайн томролттой 2, элэгний хатууралтай 4, бөөрний үрэвсэлтэй 85, цөсний хүүдийн үрэвсэлтэй 62 үйлчлүүлэгч оношлогдлоо.

Санхүү төрийн сангийнхүрээнд санхүүгийн албаны төрийн сангийн үйл ажиллагааны чиглэлээр 5 төрлийн гарын авлага материалыг 66 иргэнд тарааж, 40 иргэн санал асуулгын хуудас бөглөн саналаа өгсөн байна. Аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, нягтлан бодогчид 30 хүнийг хамруулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хэрхэн төлөвлөх, төлөвлөлтөнд иргэдийн оролцоог хэрхэн хангах, Сум хөгжлийн сангийн шинэ журмын талаар 52 иргэнийг хамруулан сургалт зохион байгуулсан байна. ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах боломжтой чиглэлүүд, газрын төлбөр, газар өмчлөл, эзэмшил, ашиглалт, байгаль орчноо хайрлан хамгаалах, мод бут тариалах, төмс хүнсний ногоо тариалах, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гэх мэт 27 нэр төрлийн 500 гаран тараах

материал, гарын авлага, зөвлөмжийг тарааж, иргэдийн сонирхсон асуултанд хариулж, зөвлөгөө өгч үйлчиллээ.

ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн Кадастрын мэргэжилтэн 2 сумын нийт 70 гаруй иргэдэд газрын кадастрын зургаар үйлчилж, 150 гарын авлага тараах материалыг иргэдэд тарааж, иргэдээс ирүүлсэн санал асуулганд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. ХХААГ-ын мэргэжилтэн малын халдварт өвчлөл, хэрхэн сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл хийж, үйл ажиллагаагаа иргэд, төрийн албан хаагчдад мэдээллийн самбараар танилцуулан сурталчилж, 50 ш поршурыг бэлтгэн тарааж, санал асуулгын хуудсыг боловсруулан 120 ширхэг хуудсаар санал авч нэгтгэсэн.

Хяналт шинжилгээ үнэлгээний хүрээнд 14 албан хаагчдад ажлын байранд нь зөвлөгөө өгч ажиллалаа.

Мөн сумдад иргэдийн санал хүсэлтийг авах хайрцагуудыг өдөрлөгөөс 3 хоногийн өмнө урьдчилан ажиллуулж, гарсан саналуудыг төрөлжүүлэн нэгтгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлүүлж ажиллалаа. Санал хүсэлтийн хайрцагаар нийтдээ 119 хуудсаар 205 санал хүлээн авч газар дээр хариулт өгөх боломжтой санал хүсэлтэд хариу өгсөн.

Сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг хуралдуулан гэмт хэргийн гаралт, нөхцөл байдлыг танилцуулж, цаашид ажиллах ажлын арга барил, заавар зөвлөгөөг өгч, ард иргэдэд 12 төрлийн нийт 360 ширхэг хууль тогтоомжийн гарын авлага бэлтгэн тараалаа. Мөн дээрх сумдуудад Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч иргэдтэй уулзаж, нийт 12 иргэнд хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч ажиллалаа.

Иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн үйлчилгээ, хуулийн этгээдийн чиглэлээр нийт 700 гаруй иргэдэд үйлчилж ажилласан ба үүнээс гадаад паспортын үйлчилгээг 68 иргэнд, сунгалт 67, иргэний үнэмлэхний олголт 12, газрын гэрчилгээ гаргуулах үйлчилгээнд 63, үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэл 64, өмчлөгчийн хүсэлтээр бүртгэлд өөрчлөлт оруулах 1, бэлэглэлийн гэрээ 3, барьцаа зээлийн гэрээ дуусгавар болгох 10, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 10, хамтран өмчлөгч хасагдах хэлцэл 5, мэдээлэл 300 гаруй иргэнд, 320 иргэнээс санал асуулгын хуудас бөглүүлж, 310 иргэнд гарын авлага тараасан байна.

Энэхүү арга хэмжээнд ЗДТГ-ын 6 хэлтэс болон харьяа 15 агентлаг газруудын 70 гаруй төрийн албан хаагчид, хоёр сумын давхардсан тоогоор 206 хүнд сургалт зөвлөгөө өгч, 1632 хүнд үйлчилгээ үзүүлж, 3686 гарын авлага материал тарааж, 645 хүнээс санал асуулга авсан байна.

Арван зургаа. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээ ирүүлсэн байдал

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны программ хангамж, техник хангамж, сүлжээний ашиглалт, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Аймгийн ЗДТГазар нь сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудтайгаа харилцан мэдээллийн эргэх холбоог шуурхай болгох үүднээс хүний нөөц, ажил хэрэг, цаг бүртгэл, албан бичиг, хэлэлцүүлэгийн зэрэг программыг багтаасан байгууллагын удирдлагын “E-office” цогц системийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, 2017 онд хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор төлбөрийг аймгийн хэмжээнд нэгдсэн байдлаар төлөх хэлбэрт шилжүүлэн хамрах хүрээг өргөжүүлээд байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрыг түшиглэн төрийн албаны мэргэшлийн шалгалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн, төрийн албаны мэргэшлийн шалгалт болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулж хэвшээд байна. Ингэснээр шалгуулагчдын сэтгэл ханамж дээшилсэн.

Аймгийн хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн программыг шаардлагатай ажилтнуудын компьютерт суулгаж өгсөнөөр холбогдох ажилтнууд уг тайлан мэдээ, судалгааг өөрсдийн ажил төрөлдөө өргөн ашиглах болж бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн үр өгөөж дээшилж ирсэн.

2016 оны ТАХ-ын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг шинэчлэн гаргаж мэдээллийн баазыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 21, бусад 15 нийт 36



байгууллага, сумдын 99, нийт 135 байгууллагыг хамруулан бүрдүүлж, тайланг ТАЗ-д хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд төсвийн 135 байгууллагад 3210 төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс 365 буюу 11,37% нь Төрийн захиргааны албан хаагч, 106 буюу 3,3% нь улс

төрийн албан хаагч, 116 буюу 3,6% нь төрийн тусгай, 2623 буюу 81,71% нь төрийн үйлчилгээний албан хаагч ажиллаж байна.

2016 оны ТАХ-ын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 36 байгууллага, 15 сумыг хамруулан гаргах хуваарь, заавар зөвлөмжийг хүргүүлэн хуваарийн дагуу тайланг нэгтгэж байна.

Байгуулагуудад төрийн албан хаагчийн мэдээллийн баазийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргах программын талаар Засаг даргын эрхлэх хүрээний агентлагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, нийт 29 албан хаагч хамрагдсан.

Бүх төрийн байгууллагууд 2016 оны Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн баазтай болж, түүнийгээ үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Арван долоо. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн

Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөнд гишүүдийн ажил үүргийн хуваарийг мөрдөж дүгнэж ажиллах, тэдний ажлыг үнэлэх шалгуур гаргаж, урамшуулал олгох, салбар зөвлөлийн гишүүдэд хурлын мэдээллийг цахим шуудангаар болон бичгээр хүргэж, хуралд оролцохдоо холбогдох хууль, журмууд судлах боломжийг бүрдүүлэх, төрөл бүрийн сургалтуудад хамруулах зэрэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Салбар зөвлөлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх үүднээс “Салбар зөвлөлийн хуралдааны дэг”, ТАСЗ-ийн 2014 оны 14, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь”-ыг 2016 оны 08 дугаар тогтоолоор, “Салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох журам”-ыг 2016 оны 12 дугаар тогтоолоор тус тус баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Сум, байгууллагуудыг салбар зөвлөлийн гишүүдийн хариуцсан сум байгууллагатайгаа ажиллах хүрээг өргөжүүлэн 2017 онд Төрийн албаны

стандартын хэрэгжилтийг шалган зааварлах үзлэгийг байгууллагууддаа хийж зөвлөгөө чиглэл өгч байна.

Салбар зөвлөлийн гишүүдийн ажлыг үнэлж дүгнэх журмыг боловсруулан, салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, 2014 онд 1940,0, 2015 онд 1 720, 2016 онд 2000,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь тэдний идэвхи санаачилгыг өрнүүлсэн ажил болсон. 2016 онд журмыг шинэчилэн баталж урамшууллын хэмжээг нэмэгдүүлээд байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд www.Dundgovi.gov.mn аймгийн вэб сайтын “Төрийн албаны салбар зөвлөл” талбар нээн ажиллуулж, Төрийн албаны салбар зөвлөлийн танилцуулга, тогтоол шийдвэр, эрх зүйн акт, шалгалтын зар, ил тод байдал хэсгүүдээр салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, ажил үүргийн хуваарь, ажлын төлөвлөгөө тайлан, салбар зөвлөлийн хуралдааны шийдвэр, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар, дүн, мэргэшлийн шалгалтын зар, дүн, төрийн жинхэнэ албаны нөөцийн мэдээлэл зэрэг үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж байна. Үүний үр дүнд байгууллагууд болон төрийн албан хаагчид мэдээллийг хурдан шуурхай авч үйл ажиллагааны шуурхай байдал хангагдаж байна.

Салбар зөвлөл 2005 оноос эхлэн байгууллагуудын удирдах албан хаагчдын ажлын эрчимжүүлэх, сэдэлжүүлэх үүпнээс аймгийн “Шилдэг менежер шалгаруулах журам”-ыг батлан хэрэгжүүлж, нийт 35 шилдэг менежер шалгаруулаад байна. Энэ нь төрийн байгууллагуудад стандартыг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгсөн арга хэмжээ гэдэг нь харагдаж байдаг.

Арван найм. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн /иргэдийн/ үнэлгээ

Тайлангийн хугацаанд Сум, байгууллагын удирдлага, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид нийт 16 хүнийг хүлээн авч уулзан, тэдний санал бодлыг сонсох, тавьсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлээ.

Төрийн албанд анх орох иргэдийн нөөцийн мэдээллээр 13 байгууллагад, төрийн албаны мэргэжлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалттай холбогдолтой хууль тогтоомжийн талаар 160 гаруй хүнд сургалт зөвлөгөө өгсөн.

Арван ес. Салбар зөвлөлийн хагас, бүтэн жилийн тайлан ирүүлсэн байдал:

2016 оны ажлын тайлан, мэдээг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу гаргаж хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. 2016 оны төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлтийг тус тус гарган хүргүүлж байна.

Хорь. Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт:

2017 оны эхний хагас жилд салбар зөвлөлд Төрийн албаны зөвлөлөөс 7, бусад байгууллага, иргэдээс 144 нийт 151 албан бичиг тоот, 20 өргөдөл гомдол, санал хүсэлт ирж, салбар зөвлөлөөс Төрийн албаны зөвлөлд 16, бусад байгууллага, иргэдэд 90 нийт 106 албан тоот бичиг гадагш явуулсны дотор Төрийн албаны зөвлөлөөс шаардсан болон цаг үеийн графикт 3 тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн болно.

Хорин нэг. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг цаашид сайжруулахтай холбогдсон ажил хэрэгч санал

Салбар зөвлөлийн үйл ажиллагаа болон төрийн албаны зарим үйл ажиллагааг цаашид сайжруулахтай холбоотойгоор салбар зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын Газрын даамал, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд улсын байцаагчийн эрх олгож, энэ ажлыг хавсран хийдэг. Энэ нь улсын байцаагч өөрийнхөө ажилд хяналт тавих зөрчил үүсч байгаа тул сумдад байгаль орчны улсын байцаагчийн тусгай орон тоог бий болгох шаардлагатай байна.

2. Боловсрол, Эрүүл мэндийн салбарт 25–аас дээш жил ажилласан бичиг хэргийн ажилтнуудын тэтгэмжийг тухайн салбарын хуулиар зохицуулсан байна.

Аймаг, сумын ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтнууд тэтгэвэрт гарахдаа Хөдөлмөрийн хуульд заасны дагуу 1 жил хүрэхгүй цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж баталж өгдөг. Төрийн захиргаанд олон жил бичиг хэргийн ажилтнаар ажиллаад тэтгэвэрт гарч байгаа албан хаагчид тэтгэмжийг 36 сараар авах гомдол гаргаад байдаг. Иймд ижил түвшний албан хаагчдад ижил түвшний тэтгэвэр олгох хуулийн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

3. Нэг ижил ажлын байранд тавигдах шаардлага байгууллага бүрт харилцан адилгүй байгаа нь тухайн ажлын байрны зохих шаардлагыг хангахгүй хүн томилогдох тохиолдол багагүй гарч байна. Иймээс тухайн ажлын байрны хамгийн доод жишиг шаардлагыг харъяалах салбарын яам болон зохих шатны дээд байгууллага нь гаргаж, тухайн жишигт нийцүүлэн байгууллага нь ажлын байрны шаардлагаа гаргадаг болгох асуудлыг хуулийн зохицуулалтад оруулж өгөх шаардлагатай байна.

4. Төрийн албаны мэргэшлийн шалгалт болон төрийн захиргааны удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд өөр аймаг хотын харъяалалтай хүмүүс ирж ажиллана гэж өргөдөл бичээд шалгалтад орчихоод нэгээр гарсан хэр нь очиж ажиллахгүй, ажлын байрны захиалгыг нөхөх ажлыг цалгардуулж байна. Иймд очиж ажиллаагүй хүмүүст хариуцлага тооцдог эрх зүйг бий болгох хэрэгтэй байна. Нөгөөтэйгүүр дээрх хүмүүс нөөцөд бүртгэгдсэн тохиолдолд ялангуяа хөдөө орон нутагт боловсон хүчин дутагдалтай байгаа байдлыг харгалзан шалгалтын материалыг салбар зөвлөл хооронд шилжүүлж болох талаар журамд өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

О.ЧУЛУУНБАТ